



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2026.06.22

Улаанбаатар хот

Сургалтын сэдэв: Өмнөговь аймгийн Ханбогд сумын Гашуун сухайтын боомтоор нүүрс тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг тээвэрчдэд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, өдөрлөг зохион байгуулах;

Зорилго: Нүүрс тээврийн үйлчилгээ эрхэлдэг иргэд, даатгуулагчдад өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл учруулахгүйгээр ажил хөдөлмөр эрхлэх, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай мэдлэг, чадвар эзэмшүүлэхэд оршино.

Сургалтад хамрагдах даатгуулагчдын тоо: 2000 (хоёр мянга);

Сургалтын төсөв: 20,000,000 (хорин сая);

Нэмэлт мэдээлэл, бүрдүүлэх материал:

Үнийн санал ирүүлэх байгууллага	-Аж ахуйн нэгж, байгууллага, сургалтын байгууллага;
Гүйцэтгэх ажил	-Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны “Журам батлах” тухай А/130 дугаар тушаалаар батлагдсан журам, жишиг хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулах;
Гүйцэтгэх хугацаа	Гэрээ байгуулснаас хойш 1 сарын дотор;
Бүрдүүлэх материал	-Дараах баримт бичгийг бүрдүүлж ирүүлнэ. • Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ; • Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын чиглэлээр мэргэшсэн багшлах хүний нөөцийн мэдээлэл, холбогдох баримт бичиг; • Сургалтын хөтөлбөр; • Ажил гүйцэтгэх үнийн санал; • Энэ чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын туршлагын талаарх танилцуулга.

Холбогдох материалыг 2026 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 17 цагаас өмнө доорх хаягаар болон undeg@ndaatgal.mn цахим хаягаар ирүүлнэ үү.

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Бага тойруу 13/1, Нийгмийн даатгалын ерөнхий газар;

Утасны дугаар: 328030-304;

---///---